

2019 оны 9-р сар

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар

Д/д	Ажил	Төрөл	Чиглэл
1	Гэр бүлийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Аз жаргалтай-Гэр бүл” дэд хөтөлбөр 2018 онд батлагдсан ба уг дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр 200 сая төгрөг зарцуулахаар шийдвэрлэгджээ. Энэ ажлын хүрээнд аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар /ГБХЗХГ/-аас санаачлан 13 сумын зорилтот бүлгийн 120 өрхөд иж бүрэн өргөө цагаан гэр гардууллаа. Тухайн өрхүүдэд өрх толгойлсон эцэг эх, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, хорих ангиас суллагдсан иргэн, залуу гэр бүлийн төлөөллүүд хамрагдсан бөгөөд Гэр бүл дэмжих туршилтын хөтөлбөрийн хүрээнд нийгмийн халамж үйлчилгээ шаардлагатай өрхүүдээс сонгогдон, дэмжлэг туслалцаа авч байгаа нь энэ юм.	Шинэлэг ажил	Нийгмийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх
2	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд дарга Д.Энхсайханаар ахлуулсан хамтарсан хяналт шалгалтын баг тус аймагт ажиллаж өмнөх онд их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 47 объектод төлөвлөгөөт шалгалтыг хийн, 20 объектод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн ба хяналт шалгалтын явцад 113 зөрчлийг илрүүлж, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 5 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зөрчлөө арилгах хүртэл түр хугацаагаар зогсоож, 79.5 сая төгрөгийн торгууль, 210 сая төгрөгийн нөхөн төлбөр ногдуулсан байна.	Салбарын хүрээнд хийгдсэн ажил	Захиргааны байгууллагын үйл ажиллагаа
3	Монгол Улсын баатар Чойн.Дугаржавын алдрыг мөнхжүүлэх ёслол хүндэтгэлийн үйл ажиллагааг түүний төрсөн нутаг Онгон суманд зохион байгууллаа. Ч.Дугаржав 1969 оны 08 дугаар сарын 12-нд Монгол Улсын баатар цол хүртжээ. Түүний баатар цолоор шагнуулсны 50 жилийн ой энэ жил давхар тохиож байна.	Салбарын хүрээнд хийгдсэн ажил	Захиргааны байгууллагын үйл ажиллагаа
4	Наран суманд 10 ортой эрүүл мэндийн шинэ төв /ЭМТ/ ашиглалтад орлоо. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан тус барилгын ажлыг Улаанбаатар хотын "Билгүүн-Од" ХХК гүйцэтгэж, гэрээт хугацаандаа хүлээлгэн өглөө. Ингэснээр тус сумын 2000 гаруй иргэн стандартын шаардлага хангасан орчин нөхцөлд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай авах, боломжтой болж байна.	Салбарын хүрээнд хийгдсэн ажил	Нийгмийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх
5	Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу төрөөс гэр бүлийг бэхжүүлэх, бие биеэ хайрлах, хүндэтгэх, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагын хүрээнд аймгийн Цагдаагийн газраас санаачлан 8 алба хаагчийн гэрлэх ёслолын арга хэмжээг 09 дүгээр сарын 19,20-ны өдрүүдэд Улаанбаатар хотод “Гэрлэх ёслолын ордон”-д зохион байгууллаа. Алба хаагчдынхаа гэрлэх ёслолыг зэрэг хийж буй нь тус байгууллагын хувьд анхдагч үйл явдал гэдгээрээ онцлог юм. Хуримлагч хосуудыг аймгийн удирдлага хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн гэрлэлтийн батлахыг нь гардуулан өгсөн байна.	Салбарын хүрээнд хийгдсэн ажил	Нийгмийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх
6	“Харилцаа холбооны хөгжил-2019” сэдэвт бүсийн зөвлөгөөн Баруун-Урт суманд зохион байгуулагдлаа. Энэхүү зөвлөгөөнд Говьсүмбэр, Дорнод, Дорноговь, Хэнтий аймаг дахь харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигчид, үйлчилгээ эрхлэгчид оролцсон. Тус зөвлөгөөний үеэр салбарын хууль, эрх зүйн орчны шинэчлэл, “ХХЗХ-ны үйл ажиллагааны стратеги 2019-2025”, “Өргөн нэвтрүүлгийн хөгжил” сэдэв	Салбарын хүрээнд хийгдсэн ажил	Дэд бүтэц, бүтээн байгуулалтын бодлогыг

	дор өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, зах зээлийн байдал, хамтын ажиллагаа, контент боловсруулалт, дамжуулалтын өнөөгийн төлөв, хөгжлийн чиг хандлага зэрэг сэдвээр хэлэлцүүлэг явагдсан.		хэрэгжүүлэх
7	Сүхбаатар аймаг, Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Замын Үүдэд суугаа Ерөнхий консулын газартай хамтран Монгол Хятад улс дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой, Хятад улс байгуулагдсаны 70 жилийн ойн баярыг тохиолдуулан Найрсаг хамтын ажиллагааны өдөрлөг зохион байгууллаа. 70 жилийн ойн баярын тохиолдуулан БНХАУ-ын санхүүжилтээр 30 оюутан сурагчдад сургалтын болон тусламжийн тэтгэлэг олгогдож байна. Мөн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд гар зураг, эсээ бичлэгийн уралдаан зарлаж, нийт 740 гаруй бүтээл ирсэнээс 78 хүүхэд шагналт байранд шалгараад байна. Уг арга хэмжээнд охион байгуулалт сайтай амжилттай оролцсон Баруун Урт сумын 2-р сургууль, Түмэнцогт, Баяндэлгэр, Халзан сумдын сургуулиудыг талархал мөнгөн шагналаар шагналаа.	Салбарын хүрээнд хийгдсэн ажил	Засаглалын бодлогыг хэрэгжүүлэх
8	БНХАУ, Монгол Улсын Онцгой байдлын байгууллага болон ӨМӨЗО-ны Шилийн голын аймаг, Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн буцалтгүй тусламж болох 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэцагаан сумын Гал түймэр унтраах 47-р ангийн барилга баригдаж ашиглалтад орлоо.	Салбарын хүрээнд хийгдсэн ажил	Захиргааны байгууллагын үйл ажиллагаа
9	Дарьганга суманд тус сумаас аймгийн ИТХ-д сонгогдсон төлөөлөгчийн санаачилгаар Эмнэлгийн хөдөлмөр магадлалын комиссын хурлыг нүүдлийн хэлбэрээр зохион байгуулж тойргийн сумдын 87 иргэний хөдөлмөрийн чадвар алдагдлын хувь хэмжээг тогтоосон байна.	Салбарын хүрээнд хийгдсэн ажил	Нийгмийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх